


Хүйтний улирал буюу 2011-2014 оны 1-4, 10-12 дугаар сарын  
Улаанбаатар хотын агаарын чанарын төлөв байдал  
**/2014 оны 10-12 дугаар сарын байдлаар/**

Улаанбаатар хотын агаарын чанарыг гэр хороолол, автозам, орон сууцны хороолол, үйлдвэрийн дүүрэг орчимд нийт 10 цэгт агаар бохирдуулах бодис болох хүхэрлэг хий ( $\text{SO}_2$ ), азотын давхар исэл ( $\text{NO}_2$ ), том ширхэглэгт тоосонцор ( $\text{PM}_{10}$ ), нарийн ширхэглэгт тоосонцор ( $\text{PM}_{2.5}$ ), нүүрстөрөгчийн дутуу исэл ( $\text{CO}$ ) болон цаг уурын үзүүлэлтүүдийг автомат болон автомат бус багажаар хэмжин тодорхойлж байна.

Хүйтний улирал буюу 2014 оны 10-12 дугаар сард агаар дахь агаар бохирдуулах бодисын сарын дундаж агууламжийг 2013 оны мөн үетэй харьцуулахад том ширхэглэгт тоосонцор **53 мкг-аар буюу 20%-иар**, нарийн ширхэглэгт тоосонцор **19 мкг-аар буюу 16%-иар**, азотын давхар исэл **12 мкг-аар буюу 21%-иар** тус тус **бага**, хүхэрлэг хийн агууламж **1.7 мкг-аар буюу 7%-иар их** байна.

2011-2014 оны хүйтний улирал (1-4 дүгээр сар, 10-12 дугаар сар)-ын Улаанбаатар хотын агаарын чанарын төлвийг агаар бохирдуулах бодис тус бүрээр дараах зургуудад харууллаа.

**Хүхэрлэг хий ( $\text{SO}_2$ )**



Зураг 1. Хүйтний улирлын хүхэрлэг хийн сарын дундаж агууламж, 2011-2014 он


2014 оны 10-12 дугаар сарын агаар дахь хүхэрлэг хийн дундаж агууламжийг 2013 оны мөн үетэй харьцуулахад 1.7 мкг-аар их буюу **өмнөх жилийн түвшинтэй ойролцоо** байна. Харин сарын дундаж агууламжийг MNS 4585:2007 Агаарын чанарын стандарт дахь хүлцэх хэм хэмжээ (цаашид АЧС дахь ХХХ гэх)-тэй харьцуулахад 10-11 дүгээр сард ХХХ-нд байсан бол 12 дугаар сард 2.4 дахин их (Зураг 1) байна.

Хүхэрлэг хийн 24 цагийн дундаж агууламжийг 10 дугаар сард нийт 234 удаа хэмжснээс 7%-д, 11 дүгээр сард 202 удаа хэмжилт хийснээс 50%-д, 12 дугаар сард 243 удаа хэмжснээс 94%-д нь АЧС дахь ХХХ-ээс давсан тохиолдол ажиглагджээ.

Хүйтний улирлын 10-12 дугаар сарын 24 цагийн дунджийн хамгийн их агууламж 12-р сард гэр хороолол (Дамбадаржаа) орчимд  $137 \text{ мкг/м}^3$  хүрч АЧС дахь ХХХ-тэй харьцуулахад

6.8 дахин их, өмнөх онд ажиглагдсан 24 цагийн дунджийн хамгийн их агууламжтай харьцуулахад 1.2 дахин бага байна.

### Том ширхэглэгт тоосонцор (PM10)




Зураг 2. Хүйтний улирлын том ширхэглэгт тоосонцрын сарын дундаж агууламж, 2011-2014 он

2014 оны 10-12 дугаар сарын агаар дахь том ширхэглэгт тоосонцор (PM10)-ын сарын дундаж агууламжийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10 дугаар сард **3 мкг**-аар буюу **2%**-иар, 11 дүгээр сард **10 мкг**-аар буюу **4%**-иар, 12 дугаар сард **147 мкг**-аар буюу **38%**-иар тус тус бага байна. Харин сарын дундаж агууламжийг АЧС дахь ХХХ-тэй харьцуулахад 10 дугаар сард 1.7 дахин их, 11, 12 дугаар сард тус бүр 2.3 дахин их (Зураг 2) байна.

Том ширхэглэгт тоосонцрын 24 цагийн дундаж агууламжийг 10 дугаар сард нийт 121 удаа хэмжсэнээс 83%-д, 11, 12 дугаар сард тус бүр 137 удаа хэмжилт хийсэнээс 89%-д нь АЧС дахь ХХХ-ээс давсан тохиолдол ажиглагджээ.

10-12 дугаар сард 24 цагийн дунджийн хамгийн их агууламж 11 дүгээр сард 100 айл орчимд  $875 \text{ мкг/м}^3$  хүрч АЧС дахь ХХХ-тэй харьцуулахад 8.7 дахин их, өмнөх онд ажиглагдсан 24 цагийн дунджийн хамгийн их агууламжтай харьцуулахад 1.8 дахин бага байна.

### Нарийн ширхэглэгт тоосонцор (PM2.5)




Зураг 3. Хүйтний улирлын нарийн ширхэглэгт тоосонцрын сарын дундаж агууламж, 2011-2014 он

2014 оны 10-12 дугаар сарын агаар дахь нарийн ширхэглэгт тоосонцор (PM2.5)-ын сарын дундаж агууламжийг 2013 оны мөн үетэй харьцуулахад 10 дугаар сард **4 мкг**-аар буюу **8%**-иар их, 11 дүгээр сард **24 мкг**-аар буюу **21%**-иар, 12 дугаар сард **38 мкг**-аар буюу **20%**-иар тус тус бага, харин сарын дундаж агууламжийг АЧС дахь ХХХ-тэй харьцуулахад 10 дугаар сард 1.1 дахин их, 11 дүгээр сард 1.8 дахин их, 12 дугаар сард 2.9 дахин их (Зураг 3) байна.

24 цагийн дундаж агууламжийг 10 дугаар сард нийт 62 удаа хэмжснээс 48%-д, 11 дүгээр сард 59 удаа хэмжснээс 76%-д, 12 дугаар сард 60 удаа хэмжилт хийснээс 92%-д нь АЧС дахь ХХХ-ээс давсан тохиолдол ажиглагджээ.

Хүйтний улирлын 10-12 дугаар сарын 24 цагийн дунджийн хамгийн их агууламж Баруун 4 зам орчим 12 дугаар сард  $336 \text{ мкг/м}^3$  хүрч АЧС дахь ХХХ-тэй харьцуулахад 6.7 дахин их, өмнөх онд ажиглагдсан 24 цагийн дунджийн хамгийн их агууламжтай харьцуулахад 2.1 дахин бага байна.

## Азотын давхар исэл (NO<sub>2</sub>)



Зураг 4. Хүйтний улирлын азотын давхар ислийн сарын дундаж агууламж, 2011-2014 он

2014 оны 10-12 дугаар сарын агаар дахь азотын давхар ислийн сарын дундаж агууламжийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10 дугаар сард **9 мкг**-аар буюу **17%**-иар, 11 дүгээр сард **12 мкг**-аар буюу **21%**-иар, 12 дугаар сард **16 мкг**-аар буюу **24%**-иар тус тус бага /Зураг 4/ байна.

Азотын давхар ислийн сарын дундаж агууламжийг АЧС дахь ХХХ-тэй харьцуулахад 10 дугаар сард хэвийн, 11, 12 дугаар сард 1.1-1.2 дахин их байна.

24 цагийн дундаж агууламжийг 10 дугаар сард нийт 207 удаа хэмжснээс 42%-д, 11 дүгээр сард 199 удаа хэмжилт хийснээс 52%-д, 12 дугаар сард 228 удаа хэмжилт хийснээс 63%-д нь АЧС дахь ХХХ-ээс давсан тохиолдол ажиглагджээ.

10-12 дугаар сарын 24 цагийн дундажийн хамгийн их агууламж Баруун 4 зам орчимд 11 дүгээр сард 135 мкг/м<sup>3</sup> хүрч АЧС дахь ХХХ-тэй харьцуулахад 3.4 дахин их, өмнөх онд ажиглагдсан 24 цагийн дундажийн хамгийн их агууламжтай харьцуулахад 1.4 дахин бага байна.

**ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР**